

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.05.31



Сайншанд сум

Тус хэлтэс нь 2024 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, иргэнд төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх, зорилгоор “Хамтын хүчээр, нийтийн төлөө” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.



Дээрх зорилтын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, бүртгэлийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Тус хэлтсийн үйлчилгээний зааланд дугаар олгогч төхөөрөмжийг шинээр байршуулсан.



2. “Цаг хэмнэсэн - цахим үйлчилгээ булан”-ийн тоуч дэлгэцээр Э-Монголиа цэсээр нэвтэрч лавлагаа үйлчилгээг 100 гаруй иргэн, киоск машинаар 400 гаруй иргэн цахимаар төлбөр төлсөн байна.



3. Гэрэгэ Киоск ХХК нь ХУРДАН төвтэй хамтран 1-р сарын 23-нд ХУРДАН КИОСК төхөөрөмжийг амжилттай нэвтрүүлсэн.



4. Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Соёмбо цогцолборт “24/7 цахим үйлчилгээний төв” 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нээлтээ хийж иргэдэд цагийн хязгаарлалтгүй улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн.



5. УБЕГ-ын даргын 2024 оны Б/297 дугаар тушаалаар Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Сайхандулаан Хөвсгөл, Эрдэнэ суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нээсэн. Ингэснээр улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх, иргэдэд түргэн шуурхай хүргэх боломж бүрдсэн.

6. УБЕГ-ын даргын 2024 оны Б/298 дугаар тушаалаар Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хөвсгөл, Эрдэнэ суманд хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх нээсэн. Ингэснээр улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх, иргэдэд түргэн шуурхай хүргэх боломж бүрдсэн.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо хөдөлгөөн” ажлын хүрээнд нийт 69 хоршоо шинээр бүртгэж гэрчилгээ олгосон.

7. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор эхний хагас жилийн байдлаар 2 удаа 100 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Судалгаанд хамрагдсан иргэдээс 74 хувь нь хүссэн үйлчилгээгээ авч чадсан, 24 хувь нь зөвөлгөө, мэдээлэл авдаг, 2 хувь нь ачаалал ихтэй байна гэж хариулсан нь иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, албан хаагчийн харилцаа, хандлага мэргэшил, мэргэжлийн ур чадвар сайжирсныг харуулж байна. Мөн үйл ажиллагааны мэдээллийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 34 хувь нь вейб сайт, 26 хувь нь facebook буюу цахим хуудаснаас 27 хувь нь хамтран ажиллагсад, үлдсэн хувь нь мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гэр бүл найз нөхдөөсөө авдаг гэсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь нийт 16165 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Төрсний бүртгэл-480
- Үрчилсний бүртгэл-3
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-19
- Эцэг тогтоосны бүртгэл-20
- Гэрлэлтийн бүртгэл -91
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-37
- Нас баралтын бүртгэл-154
- Эх нотлох баримт, мэдээллийн сангийн мэдээллийн зөрчлийг арилгах засвар өөрчлөлтийн бүртгэл-85
- Нөхөн бичилтийн бүртгэл-7
- Оршин суух хаяг тодорхойгүй төлөвт байгаа иргэнийг хаягийг суулгах-1
- Дахин олгосон гэрчилгээ-160

Иргэний бүртгэлийн нийт 3532 лавлагаа, үүнээс хууль хяналтын байгууллагад 91 лавлагаа, албан хэрэгцээнд 450, иргэнд 2991 лавлагааг тус тус олгож, үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр:

“Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу нийт 1169 иргэнд үйлчилгээ үзүүлсний дотор өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн 438, сумаас шилжин ирсэн 367, баг хооронд шилжин ирсэн 364 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулж баталгаажуулсан.

Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтыг 19960 үндэсний энгийн гадаад паспорт 4321, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих олон удаагийн хавсралт 4798, нэг удаагийн хавсралт 133 бүртгэл хөтөлж, олгосон.

Иргэний үнэмлэх олгох ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд нийт олгосон иргэний үнэмлэх 1361, үүнээс шинээр олгосон иргэний үнэмлэх 514, иргэний үнэмлэхээ гээгдүүлэн дахин олгосон иргэний үнэмлэх 88, иргэний үнэмлэхийн хугацаа дуусч 25, 45 насны сунгалт хийлгэсэн 759 иргэнд иргэний үнэмлэх олгосон.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Тоон гарын үсэг олгох батлагдсан хуваарийн дагуу төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байранд хүрэлцэн очиж тоон гарыг үсгийг олгох ажлыг тогтмол явуулж байна. Одоогийн байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд тайлант хугацаанд 2059 иргэнд тоон гарын үсгийг олгоод байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулах, бүртгэлийн чанар, хяналтыг дээшлүүлэх зорилготой ажиллалаа.

Хагас жилийн байдлаар хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 3714 мэдүүлгийг хүлээн авсан. Үүнээс:

- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 152
- Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгүүлэх-66
- Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт -7
- Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -203
- Худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-456
- Бэлэглэх гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-116
- Арилжих гэрээ-6
- Барьцааны гэрээ-1170
- Барьцааны гэрээ дуусгавар болгох-1188
- Өв залгамжлах эрхийн бүртгэл-54
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх -2
- Бүртгэлд өөрчлөлт оруулах-168
- Лавлагаа-48 тус тус бүртгэж үйлчилгээ үзүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцуулахаар ирүүлсэн 19 хүсэлт нотлох баримтыг үндэслэн хяналтын байцаагчийн дүгнэлтийг гаргуулан гэрчилгээг дахин бичиж олгосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх бблавлагааг хүргүүлсэн. Нийт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 3714 мэдүүлэг авч, бүртгэн, үйлчилгээний хураамжийн 65.425.838 төгрөгийг улсын төсөвт, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татвар 442.073.766 төгрөг, тэмдэгтийн хураамж 2.319.599 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS программд алдаатай цахимжигдсан бүртгэлийг архивын эх нотлох баримттай тулган шалгаж илэрсэн зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд нийт 836 үйлчилгээг үзүүлж бүртгэл хөтөлсөн. Үүнд:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээд нийт - 138
- Хуулийн этгээдийн мэдээлэлдээ оруулсан өөрчлөлт нийт 171/ Салбар 11/
- Хуулийн этгээдийн мэдээллийн сан, хувийн хэргээс нийт 34 лавлагаа, хуулбар олгосон.

- Тамга тэмдгийн хяналтын дугаар 206 олгож, 34 хуулийн этгээдийн тамга, тэмдгийг хураан авсан.
- Хуулийн этгээдийн оноосон нэр 253 баталгаажуулсан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр:

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 17 заалт бүхий төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр боловсруулан, хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант хугацаанд бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хяналт шалгалтын газар, Иргэний улсын бүртгэлийн газартай хамтран ирүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 3/10685 дугаар албан бичгээр ирүүлсэн “Чиглэл”, Хяналт,шалгалтын газраас 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 6/4865 дугаар албан бичгээр ирүүлсэн “Үүрэг, даалгавар”, УБЕГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/4924 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж”, Хяналт,шалгалтын газраас 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6/5641 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Чиглэл”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж нийт 1126 бүртгэлийг шалгаж 40 зөрчлийг илрүүлэн арилгуулж тайлан, илтгэх хуудсыг тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн.

Нас барсны бүртгэл давхар бүртгэгдсэн, нэг хаягт давхар бүртгэлтэй, хоёр регистртэй 198 бүртгэлийг шалгаж 101 зөрчлийг дүгнэлтээр арилгасан.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалтыг 3 удаа хийсэн.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1112, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 514, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 46, архивын чиглэлээр 233 бүртгэл шалгаж, нийт 246 зөрчил илрүүлэн арилгуулах арга хэмжээ авч ажиллав.

Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 13, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 27 нийт 40 дүгнэлтийг боловсруулан зөрчлийг арилгасан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.






Бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт болон сар бүрийн мэдээ, судалгааг нэгтгэн гаргаж илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх үүднээс улсын бүртгэгчдэд дотоод албан бичгээр 6 удаа чиглэл, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Мөн дүгнэлтээр засагдаж буй улсын бүртгэгчдийн гаргасан зөрчлийн судалгааг бүртгэгч тус бүрээр гаргаж санамж анхааруулга өгч байна.



Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 210 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 214 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 5990.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.



Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж ажилладаг. Эхний 5 сарын байдлаар хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 214 зөрчлийн хэрэг материалыг аймгийн Прокурорын газарт хуулийн хугацаанд бүртгүүлж, хянуулсан.

Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын улсын бүртгэгч нартай хамтран ажиллаж хугацаатай бүртгэлүүдээр иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж сар бүр хийсэн ажлын мэдээ, үр дүнг тооцож ажиллаж байна.

Мэдээлэл технологийн ажилтантай хамтран хуулиар тогтоосон хугацаатай 3 бүртгэлээр шторк бэлтгэн 8500 иргэнд мэдээлэл хүргэсэн.

Эхний 5 сарын байдлаар онд нийт 530 ширхэг гарын авлага, санамж, боршуур хэвлэж иргэдэд тараасан.

Архивын ажлын хүрээнд:

Иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээний маягт болох ИУБ-11 маягт 480 ширхэг, ИУБ-12 маягт 3 ширхэг, ИУБ-13 маягт 19 ширхэг, ИУБ-14 маягт 20 ширхэг, ИУБ-15 маягт 91 ширхэг, ИУБ-16 маягт 37 ширхэг, ИУБ-18 маягт 154 ширхэг, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 1275 ширхэг ИУБ-31 маягт, нийт 2079 ИУБ маягтыг архивын санд байрлуулсан, баяжилтыг тухай бүр хийсэн.

Тайлант хугацаанд өөр аймаг, хотоос шилжин ирсэн 699 иргэний хувийн хэргийг архивын санд байрлуулж, аймаг болон нийслэл рүү 438 хувийн хэрэг явуулсан.

Тус архивт өнөөдрийн байдлаар насанд хүрсэн 47526 иргэний, насанд хүрээгүй хүүхдийн хувийн хэрэг 23521, нас барсан 93521 иргэний хувийн хэрэг, шинэчилсэн

бүртгэлд хамрагдаагүй 174 иргэн, харьяатаас гарсан 95 иргэн, тодорхойгүй төлөвтэй 1725 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн 2503 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хуулийн этгээдийн 836 бүртгэлийн баримтыг архив руу шилжүүлснийг ERS програмд архивлах төлөвт 100% шилжүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт үл хөдлөх эд хөрөнгийн 15434, газрын 9398нийт 24925хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн 192, газар өмчлөх эрхийн 134 хувийн хэрэг шинээр үүссэнийг архивт хүлээн авсан.

Нийт эд хөрөнгийн 3714 бүртгэл архивт хүлээн авч байршуулсан.

Сар бүрийн архивын тоон мэдээг гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн.

Хүний нөөцийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/424 тушаалаар тус хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг 29 баталсан.

Тайлант хугацаанд тус хэлтэс нь төрийн захиргааны 25, төрийн үйлчилгээний 4, гэрээт 2 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хэлтсийн даргын Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 8 тушаал гаргасан байна. Үүнд:

- Ээлжийн амралтын хуваарь батлах тухай-1
- Ажилд томилох, ажлаас чөлөөлөхтэй холбоотой 2,
- Цалин хөлс, ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой-5 тушаал гарсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 15 тушаал гарсан байна. Үүнд:

- Ээлжийн амралтын хуваарь батдах тухай-1
- Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай-1
- Ажилд томилох, ажлаас чөлөөлөх, ажлаас чөлөөлж, албан тушаалд томилох, тухай -5,
- Сахилгын шийтгэл оногдуулах тухай-3,
- Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай-1,
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай-1,
- Мөнгөн урамшуулал олгох тухай-1
- Сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тухай-1
- Сумын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тухай-1

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах арга хэмжээ авахуулсан 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.

Хуульд заасан бусад төрлөөр буюу Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт зөрчсөн, ёс зүйн зөвлөлийн шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна.

Төрийн захиргааны албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газар дахь салбар зөвлөлөөс санал уламжилсны дагуу төрийн захиргааны 12 албан хаагчдад зэрэг дэв ахиулах болон шинээр зэрэг дэв олгосон. Үүнд:

Ахлах түшмэлийн гутгаар зэрэг-1
Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг – 1 албан хаагч,
Дэс түшмэлийн гутгаар зэрэг- 3 албан хаагч
Дэс түшмэлийн дэд зэрэг- 3 албан хаагч,
Дэс түшмэлийн тэргүүн зэрэг-5 албан хаагчдад олгосон байна.

УБЕГ-аас 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 3/4644 тоот албан бичигт ажил үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчиж бүртгэл хөтөлсний улмаас гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцлийг бүрдүүлж эрүүгийн хэрэгт холбогдох асуудал цөөнгүй гарч байгаа талаар сануулан Улсын бүртгэлийн багц хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хууль холбогдох дүрэм журам, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ авилга ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, хуулийн хүрээнд ажиллахыг шинээр томилогдсон 3 улсын бүртгэгч нарт танилцуулсан, УБЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 13-ны өдрийн А/1716 тоот тушаалаар баталсан байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын үйлчилгээний стандарт, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн санамж эрхзүйн баримт бичигтэй танилцуулж Авилгаас ангид байх баталгааны хуудсанд гарын үсэг зуруулан албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргасан.

Хэлтсийн 26 алба хаагч улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системд тавигдсан сургалт мэдээлэлтэй тухай бүр танилцаж, бие даах хичээл болон чиглэл, үүрэг даалгаврыг бүрэн судалж шалгалтыг 85-100 хувийн амжилттай өгсөн.

Шинээр томилогдсон 3 улсын бүртгэгчид хүний нөөц, сургалтын нэгдсэн системд нэвтрэх эрхийг нээлгэж, хичээлийг судлуулж эхлээд байна.

Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Албан хэрэг хөтлөлт: Тайлант хугацаанд 291 албан бичиг явуулж, ирсэн 339 албан бичгийг хүлээн авч, заавар, стандартын дагуу бүртгэж, даргын цохолтоор холбогдох албан хаагчдад шилжүүлэн, хариутай 171 албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж, хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 5, хүний нөөцтэй холбоотой тушаал 15, бусад шийдвэрийн баримт бичгийг бүртгэн, танилцуулах хуудсаар нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн. Хэлтсийн даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2, хүний нөөцтэй холбоотой 8 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, даргаар батлуулан, холбогдох албан хаагчдад танилцуулсан

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт: Тус хэлтэст тайлант хугацаанд Засгийн газрын 11-11 төвд-2 гомдол, бичгээр 19 өргөдөл гомдол ирсэн байна.

Нийт 21 өргөдөл гомдол ирүүлснээс

- Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой-3,
- Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой -1
- Гадаадад зорчих эрхийн бүртгэлтэй холбоотой-8,

- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой-4,
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой-5

Байгууллагын архивын чиглэлээр: Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтын дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, төслөөр хянуулахаар аймгийн Архивын тасагт өгсөн.

- Улсын бүртгэлийн хэлтсийн 2021-2023 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг үйлдсэн.
- Улсын бүртгэлийн хэлтсийн Байнга хадгалах 2009-2016 оны хэлтсийн даргын 8 хадгаламжийн нэгжийн 267 хуудас тушаалыг Архивын ерөнхий газрын мэдээллийн санд цахимаар оруулсан.
- Архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, ашиглалтын талаарх мэдээ гаргаж аймгийн Архивын тасагт хүргүүлсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг нэгдье” шторк зурагт хуудсыг байгууллагын нэг цонхны үйлчилгээний хэсэгт байршуулсан дэлгэцээр тогтмол явуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Соёмбо цогцолборын үүдэнд, үйлчилгээний заалны хананд “Авлигын эсрэг нэгдье” шторк хуудсыг мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэн ажиллалаа



Бид авилга авахгүй, та авилга өгөх хэрэггүй, бид танд үйлчлэх үүрэгтэй санамж хуудсыг үйлчилгээний заал болон мэдээллийн самбарт байршуулсан

Хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний үүдэнд болон архивын өрөөний гадна хаалганд “АВИЛГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ХАМТ ОЛОН” гэсэн сурталчилгааны хуудсыг наан байршуулсан. Хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 дугаарыг байршуулсан.



Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хэлтсийн төрийн захиргааны нийт албан хаагчид ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж, хэлтсийн дарга баталгаажуулсан.

Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлан “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тухай бүр нь шинэчилсэн, мэдээ мэдээллээр иргэдийг ханган ажиллаж байна

Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, авлигын хор уршгийг алба хаагчдад таниулах зорилгоор Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг "Мэдээллийн ил тод байдал", "Шүгэл үлээгчийг хамгаалах, хамтран ажиллах" зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулан ажилласан. Нийт алба хаагчдад Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тусгагдсан заалтуудыг танилцуулан холбогдох мэдээллийг өгч ажилласан

Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэн, байгууллагаас санал, гомдол ирээгүй.

Мэдээллийн технологи, програм хангамж, тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд:

Мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

Хэлтсийн нийт 28 албан хаагчийн 38 компьютерийн үйлдлийн системийн нууц үг болон програмд нэвтрэх нууц үгийг сольж баталгаат гарын үсэг зуруулсан.

Серверийн аюулгүй байдалд байнгын хяналт, цоож, лац, дохиоллын системийг тогтмол шалгаж, цэвэрлэгээ үйлчилгээг байнга хийж байсан. Мөн серверийг асааж унтраах тохиолдолд ашиглалтын дэвтэр хөтлөлтийг байнгын тэмдэглэл хөтөлсөн. Хэлтсийн албан хаагч нарын ашиглаж байгаа гадаад болон дотоод сүлжээний кабелийг хаягжуулсан. Албан хаагч нарын компьютер, принтерийн тэжээлийн залгуурыг салгаж аюулгүй ажиллахаар болгосон.

14 сум болон хэлтсийн албан хаагч нарын компьютерт иргэний улсын бүртгэлийн програм, гадаад паспорт, зураг засвар дээр ажиллах түүлүүдийг шинэчилж суулгаж таниулсан.

ХУБ-ын дотоод сүлжээний свичийг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Мандах сумын видео конвертор, Замын-Үүд, Мандах сумын рөүтерийн тэжээлийн залгуур болон ракин урт залгууршатсан, Иххэт, Хөвсгөл сумын суурин компьютерийн BIOS-ын батерей ажиллахгүй байсныг шинээр сольж хэвийн үйл ажиллагааг хангасан.

Ахлах нягтлан бодогч, Хөвсгөл, Замын-Үүд, Сайншанд сумын суурин компьютер, 5 ширхэг зөөврийн компьютерийг форматлаж шаардлагатай програмуудыг суулгаж бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд хэвийн ажиллагаанд оруулсан.

Хэлтсийн дарга, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн 3 бүртгэгч, иргэний улсын бүртгэлийн тасгийн 4 бүртгэгч, бичиг хэргийн ажилтан, ахлах нягтлан бодогч, мэдээллийн технологийн ажилтан, Замын-Үүд сумын 2 улсын бүртгэгч нарын принтерийн алдааг тухай бүрд нь засаж таниулж ажилласан. Мөн шинээр Olivetti, 3 үйлдэлт 3 ширхэг принтерийг хэлтсийн албан хаагч нарын компьютерт таниулж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Цаг хэмнэсэн цахим булангийн телевиз, Гэрэгэ киоск машин, мэдрэгчтэй дэлгэц, принтерийн алдаа гэмтлийг тухай бүрд нь засаж бэлэн байдалд оруулж ажилласан.

Соёмбо цогцолборт Улсын бүртгэлийн цахим КИОСК машиныг суурьлуулж улсын бүртгэлийн сүлжээнд холбож үйлчилгээ үзүүлэхэд бэлэн болгосон.

Сумдын улсын бүртгэгч нарт програмын шинэчлэлт, сүлжээ, компьютер, принтерийн алдаа гарах бүрд онлайн аргаар холбогдон заавар зөвлөгөө өгч ажилласан.

Онлайн болон танхимын сургал хийхэд техникийн бүрэн байдлыг ханган ажилласан.

Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах чиглэлээр дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд:

- Засгийн газрын 2024 оны 2 сарын 24-ний өдрийн 83 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 9 албан хаагчдад 5 жилийн мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн.
- УБЕГ-ын даргын 2023 оны 01 сарын 20-ны өдрийн “Хоол унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” Б/100, Б/101 тушаалаар хяналтын улсын байцаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдын хоол унааны нэмэгдлийг, 2023 оны 01 сарын 20-ны өдрийн Б/102 дугаар тушаалаар хэлтсийн төрийн захиргааны албан хаагч, гэрээт ажилтанд олгох хоол, унааны нөхөх төлбөрийг нэмэгдүүлэн 2023 оны 01 дүгээр сараас олгож эхэлсэн.
- УБЕГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/218 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний зарим албан тушаалын нэр, зэрэглэлийг өөрчилсөн.
- Засгийн газрын 2024 оны “Тогтоол хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 тогтоолы, Засгийн газрын 2024 оны “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалин нэмэгдсэн.

Санхүү, аж ахуй үйлчилгээний ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны 6 сарын байдлаар 144810.7 мянган төгрөгийн үйлчилгээний орлогыг олж 144810.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсөвт торгууль, шийтгэлийн орлогоор 5990.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжаар 29584.9 мянган төгрөг, үл хөдлөх борлуулсны орлогоор 442076.7 мянган төгрөг нийт 477651.6 мянган төгрөгийн орлого оруулсан.

Тус хэлтсийн зардлын төсөв 2024 онд 910495.1 мянган төгрөгөөр батлагдсан. 6 сарын байдлаар 522635.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 428298.2 мянган төгрөгийг зохих зардлуудад төсвийн хуваарийн дагуу зарцуулан ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн программ ашиглаж олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд байнгын хяналт тавьж, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг 5 удаа хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СТСХэлтэст болон УБЕГ-ын СААХ-т хүргүүлсэн. 2024 оны 1-р улирлын санхүүгийн тайланг гаргаж, УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. 2023 оны санхүүгийн тайлангийн аудит түүврээр орсон. Зөрчилгүй ажилласан.

УБЕГ-аас болон бусад байгууллагаас 10419.1 мянган төгрөгийн үнэт цаас, маягт болон 669.5 мянган төгрөгийн бусад бараа материалыг бэлтгэж хангалтыг тасалдуулалгүй, мөн бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан.

2024 оны 6 сарын байдлаар 359 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь үндсэн хөрөнгө орлого авах, үнэт цаасны тооллого, хүчингүй болгосон үнэт цаас, үнэт цаасны зарцуулалт зэргээр 4 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн А/380 тоот захирамжаар орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүждэг зарим гентлаг, байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцон 4 дүгээр сарын 1-ний өдрөөс олгохыг зөвшөөрсний дагуу орон нутгийн төсвөөс 17354.3 мянган төгрөгийг албан хаагчдад олгоод байна.


Аймгийн Засаг даргын 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/406 тоот захирамжаар УИХ болон орон нутгийн сонгуулийн ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулахад шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж 19832050 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үйлчилгээний зааланд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд дугаар олгох төхөөрөмж, 2 компьютер, 3 принтер авч байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийн дансанд бүртгээд байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 14 сумын 65 хэсгийн хорооны 67 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулсан. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэж, сумдын сонгуулийн хэсгийн хорооны даргад акт үйлдэж хүргүүлсэн.



Итгэмжлэгдсэн ажилтануудад 2024 оны 05 сарын 29-ний өдөр МУИХ-ын сонгуультай холбоотой цахим сургалтыг зохион байгуулсан.



БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд: Тус хэлтэс нь “Эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд өглөө бүр ажил эхлэхээс 10 минутын өмнө ажилтан, албан хаагчдын дунд “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”-ийг хийлгэж хэвшлээ.

Энэ нь алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн явцад бий болсон ядралыг сэргээх, ажлын чадварыг нэмэгдүүлэн улмаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх үр дүнтэй юм



Хандивын аянд нэгдсэн нь

Тус хэлтэс нь “Бүртгэлийн илч” аяны хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчид өвөлжилт хүндэрсэн малчин өрхөд, дэм үзүүлэх 1 сая төгрөг хандивласан.



Цаг агаарын давагдашгүй хүчин зүйлтэй нүүр тулж, зудад нэрвэгдсэн хүнд нөхцөл байдалтай байгаа малчин иргэддээ сэтгэлийн дэм хүргэх зорилгоор уг аянд нэгдэж 500,0 мянган төгрөгийг хандивлаж аймгийн Онцгой комисст гардуулан өгсөн. Мөн тус хэлтсийн малчин өрх 2 албан хаагчид тус тус 100,0 мянган төгрөг хандивласан.

Монгол улсын үндсэн хууль хуулийн батлагдсаны ойг тохиолдуулан алба хаагчдад Үндсэн хуулийн түүхэн замнал, хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдээр сургалтыг зохион байгуулсан. Мөн алба хаагчдын дунд Монгол улсын үндсэн хуулиар танин мэдэхүйн асуулт, хариултыг зохион байгууллаа.



**Бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд:
“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” зохион байгуулсан байдал:**

Иргэдэд улсын бүртгэлийн хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, бүртгэлийн үйлчилгээ, мэдээллийг олон төрлийн байдлаар нийтэд шуурхай, чанартай хүргэхэд анхаарч, дараах ажлыг зохион байгууллаа.

Алтанширээ суманд 05 сарын 25-27-нд “Нээлттэй хаалганы өдөрлөг, Тойг, Зараа, Хаяа, Чулуунгишгэр багуудын төв дээр зохион байгуулж төрийн үйлчилгээг хүргэх нээлттэй хаалганы өдөрлөг 104 иргэнд мэдээлэл өгсөн.



Улаанбадрах суманд 2024оны 05 сарын 17-ны өдөр 1 дүгээр багт, 05 дугаар сарын 30-нд 2 дугаар багт нийт 65 иргэдэд мэдээлэл хийсэн.



Иххэт суманд 2024 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 104 иргэнд мэдээлэл хийсэн



НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ
2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдав.

- Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх
- Гадаад паспортын захиалга авах
- Төвн гарын үсэг өлгөх
- Иргэний оршин суугаа хянг дээр амьдарч буй иргэдийн мэдээлэл шалгах
- Байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээлэл шалгах

УЛСЫН БҮРТГЭГЧ
92099023

Өргөн суманд 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 84 иргэнд мэдээлэл хийсэн




Мандах суманд 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэнд мэдээлэл хийсэн



БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАСАН БАИДАЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийн хүрээнд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаар байгууллагын ажилчдад мэдээлэл хийж ажилласан.


Аймгийн Онцгой байдлын газраас 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ" сэдэвт сургалтанд тус хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга, иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг хамрагдсан.



Мөнхэлтсийн албан хаагчдын аранз, аранзны бүрдэл, хувцасны бэлэн байдлыг хангуулж ажилласан.

Хэлтсийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг баталж, мөн хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хянуулж батлуулсан.

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16.00 цагт Зарлан мэдээллийн дуут дохио 1 дуугарахад хэлтсийн албан хаагчид ширээн доогуур орж аюулгүй байдлаа хангаж, 2 удаа дуугарахад баруун гарын дүрмийг баримтлан объектоос аюулгүйн гарцаар гарч аюулгүйн талбайд нүүн шилжиж ажилласан.



Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал нь Дорноговь аймгийн DSB телевизд Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар болон Улсын бүртгэлийн хэлтээс хийж буй онцлог ажлууд, цаг үеийн мэдээ мэдээллийг хийж олон нийтэд сурталчилсан.



Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлан зохион байгуулдаг “Хуульчдын Про-боно” болон “Нээлттэй Дорноговь” чуулган 2023 оны 05 сарын 01-ний өдөр зохион байгуулагдлаа. Тус өдөр байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилж, иргэдэд зөвлөгөө ажиллалаа




Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын нэгдсэн сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нээж үг хэлсэн. Нэгдсэн сургалтыг “Авлига албан тушаалын гэмт хэрэг”, Хандлага ба харилцаа” зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж, “Ёс зүй манлайлал” сэдвээр манлайллын боловсролын үндэсний төвийн илтгэгч багш Б.Батням илтгэл танилцуулсан.



Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний тогтоол, төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг дагаж мөрдөх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгөх, ёс зүйн дэд хороодод арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Дорноговь аймагт ажиллаж, нийт төрийн алба хаагчдад Төрийн алба хаагчийн ёс зүй, Авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан.



2024 оны 3,6 зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтад оролцогчдын хурууны хээ таниулах систем дээр иргэний улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг хариуцан ажилласан



Сар бүрийн 3-нд “Донор тандаа баярлалаа” уриан дор аймгийн УЗХ-той хамтран зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон .



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж буй “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөдөлгөөн “ЦАГ ГАРГАЯ” аянд нэгдэв.



“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан уламжлал болгон зохион байгуулдаг “Албан хаагчдын гэр бүлийн өдөрлөг”-ийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.



Сайхандулаан сумын ЗДТГ болон Нийтлэг үйлчилгээний газартай хамтран шинээр өрх айл болж, гал голомтоо бадрааж буй залуу хос н.Анхбаяр, Б.АриунтунгалагболонТ.Ган-Очир, Б.Хулан нарт “Гэрлэлтийн батламж” гардуулан “Монголын гэр бүлийн тангараг өргүүлэх ёслол”-ыг зохион байгуулж хүндэтгэл үзүүллээ.





Дорноговь аймагт шинээр төрсөн хүүхдүүдэд 2024 оны 02 сар хүртэл Голомт банк хадгаламжийн дэвтэр, гарын бэлэг гардуулан өгсөн.

